



**МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ САЙН ДУРЫН ХОРООДЫН
ЗОХИОН БАЙГУУЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ НИЙТЛЭГ ЖУРАМ**

**Улаанбаатар хот
2013 он**

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны 11 дүгээр
сарын 2-ны өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.7, 48.10, Монголын Хуульчдын холбооны дүрмийн 4.6 дугаар зүйлийн 4, 4.10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус удирдлага болгон Хуульчдын холбооны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, Монголын Хуульчдын холбооны дүрмийн 8.16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг тус тус үндэслэн “Монголын Хуульчдын холбооны сайн дурын хороодын зохион байгуулалттай холбоотой нийтлэг журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, Монголын Хуульчдын холбооны дүрмийн 7.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн “Монголын Хуульчдын холбооны Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны тухай журам”-ыг хоёрдугаар хавсралтаар, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3, 48 дугаар зүйлийн 48.9.3, Монголын Хуульчдын холбооны дүрмийн 4.13 дугаар зүйлийн 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн “Хуульчийн тангараг өргөх ёслолын журам”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэхүү тогтоолыг 2013 оны 11 дүгээр сарын 2-ны өдрөөс эхлэн дагаж мөрдүүлсүгэй.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ

Д.БАТСҮХ

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ САЙН ДУРЫН ХОРООДЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ НИЙТЛЭГ ЖУРАМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 дүгээр зүйл. Журмын зорилт

1. Энэ журмын зорилт нь Монголын Хуульчдын холбоо /цаашид “Холбоо” гэх/-ны тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэх зорилго бүхий сайн дурын хороо /цаашид “Хороо” гэх/-г үүсгэн байгуулах, бүртгүүлэх, өөрчлөн байгуулах, хорооны удирдлага, зохион байгуулалт, хяналтын бүтэц, хорооны гишүүний эрх, үүргийг тогтоох, хороог татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2 дугаар зүйл. Журмын үйлчлэх хүрээ

1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль¹, Монголын Хуульчдын холбооны дүрэм² /цаашид “Холбооны дүрэм” гэх/-д өөрөөр заагаагүй бол Холбооны дэргэдэх сайн дурын хороотой холбоотой нийтлэг харилцааг энэ журмаар зохицуулна.

2. Шүүгч, прокурор, өмгөөлөгчдийн хорооны онцлогтой холбогдсон зарим харилцааг тухайн хорооны дүрэмд энэ журамд зааснаас өөрөөр зохицуулж болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХОРОО, ТҮҮНИЙ ГИШҮҮНЧЛЭЛ

2.1 дүгээр зүйл. Хороо, түүний хэлбэр

1. Хороо нь хуулиар байгуулагдсан болон гишүүдийн санаачилгаар байгуулагдсан сайн дурын хороо гэсэн хэлбэртэй байна.

2. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулиар нэрлэн заасан хороог “хуулиар байгуулагдсан сайн дурын хороо” гэнэ.

3. Холбооны тодорхой нэг чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаа явуулахаар гишүүд сайн дурын үндсэн дээр байгуулсан хороог “гишүүдийн санаачилгаар байгуулагдсан сайн дурын хороо” гэнэ.

[/Энэ хэсэгт Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2015 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хурлын 6 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/](#)

4. Хуулиар байгуулагдсан сайн дурын хороо нь хуульд нэрлэн заасан хуульчдын заавал гишүүнчлэлтэй байна.

5. Гишүүдийн санаачилгаар байгуулагдсан хорооны гишүүнчлэл нь сайн дурын байна.

6. Хороо нь тодорхой чиглэлээр дэд хороо байгуулан ажиллаж болно. Дэд хороотой холбогдсон харилцааг Хорооны дүрмээр зохицуулна.

¹ “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 11 дугаарт нийтлэгдсэн.

² Хуульчдын анхдугаар Их хурлын 2013 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн 3 дугаар тогтоолоор батлагдсан.

2.2 дугаар зүйл.Хорооны үйл ажиллагааны чиглэл

1.Хороо нь Холбооны тодорхой нэг чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

2.Хорооны үйл ажиллагаа нь үүсгэн байгуулагдсан бусад хороо болон чиг үүргийн хорооны үйл ажиллагаатай давхардаж болохгүй.

3.Хороо нь зарим үйл ажиллагааг Холбооны эрх бүхий байгууллагын бичгээр олгосон зөвшөөрлийн үндсэн дээр явуулж болно.

2.3 дугаар зүйл.Хорооны оноосон нэр

1.Хороо оноосон нэртэй байх бөгөөд тухайн хорооны нэр нь чиг үүргийн болон бусад хорооны нэртэй давхардаагүй байна.

2.Хороог Холбооны зөвлөлөөс батламжилснаар хорооны нэрийг хэрэглэх онцгой эрхтэй болно.

2.4 дүгээр зүйл.Хорооны гишүүнчлэл

1.Хороог 20-оос доошгүй хуульчдын гишүүнчлэлтэйгээр үүсгэн байгуулна.

2.Хуульд нэрлэн заасан өмгөөлөгчдийн хороонд шүүхэд төлөөлөх эрх нээлгэсэн хуульч, прокурорын хороонд прокуророор томилогдсон хуульч, шүүгчдийн хороонд шүүгчээр томилогдсон хуульч заавал гишүүнчлэлтэй байна.

3.Энэ журмын 2.1 дүгээр зүйлийн 2-т зааснаас бусад хороонд Холбооны гишүүнчлэлийн эрх болон хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл нь хүчинтэй байгаа хуульч гишүүн байж болно.

[/Энэ хэсэгт Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2015 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хурлын 6 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/](#)

4.Хорооны гишүүний бүртгэлтэй холбогдсон харилцааг Холбооноос баталсан журмаар зохицуулна.

2.5 дугаар зүйл.Хорооны гишүүний эрх

1.Хорооны гишүүн нь дараах эрх эдэлнэ:

1.1.хорооны гишүүдийн хуралд оролцож, хурлаар хэлэлцэж байгаа бүх асуудлаар санал өгөх;

1.2.Холбооны удирдлага, бүтцийн байгууллагад хорооны нэрийн өмнөөс сонгох, сонгогдох;

1.3.тухайн хорооны талаарх бүх мэдээллийг авах, санхүүгийн болон бусад баримт бичигтэй танилцах;

1.4.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Холбооны дүрэм, энэ журам болон хорооны дүрэмд заасан бусад эрх.

1.5.Холбоо, хорооны үйл ажиллагаатай холбоотой санал санаачилга гаргах, үзэл бодол, гомдол хүсэлтээ Удирдах зөвлөлд тавих, холбооны Зөвлөлд уламжлуулах;

[/Энэ зүйлийн 5 дахь хэсгийг Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2019 оны 6 дугаар сарын 04-ний өдрийн хурлын 10 дугаар тогтоолоор нэмсэн/](#)

**ГУРАВДУГААР БҮЛЭГ
ХОРОО БАЙГУУЛАХ**

3.1 дүгээр зүйл.Хороо байгуулах

1.Хороог шинээр, эсхүл үйл ажиллагаа явуулж байгаа хороог өөрчлөн байгуулах /нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх/ замаар байгуулж болно.

3.2 дугаар зүйл.Хорооны үүсгэн байгуулагч

1.Хорооны үүсгэн байгуулагч нь Холбооны гишүүнчлэлийн эрх болон хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл нь хүчинтэй байгаа хуульч байна.

[/Энэ хэсэгт Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2015 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хурлын 6 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/](#)

2.Хорооны үүсгэн байгуулагч нь тухайн хорооны гишүүнээр элсэхгүй байж болно.

3.Хороог үүсгэн байгуулах, Холбооны зөвлөлөөр батламжлуулах ажлыг хорооны үүсгэн байгуулагчдын хурлаас эрх олгогдсон хуульч зохион байгуулна.

[/Энэ зүйлийн 4 дэх хэсгийг Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2015 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хурлын 6 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/](#)

3.3 дугаар зүйл.Шинээр хороо үүсгэн байгуулах

1.Үүсгэн байгуулагчдын хурлын шийдвэрээр хороог үүсгэн байгуулна.

2.Хороо үүсгэн байгуулах хуралд үүсгэн байгуулагч бүр нэг саналын эрх эдэлнэ.

3.Хороо үүсгэн байгуулах хурлаар дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ:

3.1.хороо байгуулах тухай;

3.2.хорооны дүрэм;

3.3.хорооны гишүүдийн тоо, гишүүнээр элсүүлсэн байдал;

3.4.удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох.

4.Хороог 20-оос доошгүй хуульч үүсгэн байгуулах бөгөөд бүх үүсгэн байгуулагч оролцсоноор хороо үүсгэн байгуулах хурал хүчин төгөлдөр болох бөгөөд уг хуралд оролцогчдын дийлэнх олонхын саналаар шийдвэр гаргана.

5.Хороо үүсгэн байгуулах хурлын даргыг үүсгэн байгуулагчдаас сонгоно.

3.4 дүгээр зүйл.Хороог батламжлуулах

1.Хороо байгуулах тухай шийдвэр гарснаас хойш 14 хоногийн дотор хороог батламжуулахаар холбогдох баримт бичгийг Холбооны Тамгын газарт хүргүүлнэ.

2.Хороог бүртгүүлэхэд Монголын Хуульчдын холбооны бүртгэлийн нэгдсэн журмын Зургадугаар бүлэгт заасныг баримтлана.

[/Энэ хэсгийг Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2015 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хурлын 6 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/](#)

3.5 дугаар зүйл.Хорооны дүрэм

1.Хорооны дүрэм нь түүнийг үүсгэн байгуулах үндсэн баримт бичиг байна.

2.Хорооны дүрэмд дараах зүйлийг заавал тусгана:

2.1.хорооны бүрэн болон товчилсон оноосон нэр;

- 2.2. удирдах зөвлөлийн гишүүдийн тоо;
- 2.3. хорооны гишүүдийн хурал болон удирдах зөвлөлийн Холбооны дүрэм, энэ журамд зааснаас бусад бүрэн эрх;
- 2.4. хорооны үйл ажиллагааны зорилго, чиглэл;
- 2.5. хорооны дүрэмд тусгахаар энэ журамд заасан бусад зүйл.

3. Хорооны дүрэмд Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль болон Холбооны дүрэм, бусад хууль тогтоомжтой зөрчилдөөгүй зүйлийг тусгаж болно.

4. Хороо нь гишүүний шаардлагаар Хорооны дүрэм, түүнд орсон нэмэлт, өөрчлөлтийг танилцуулах үүрэгтэй.

[/Энэ хэсэгт Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2015 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хурлын 6 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/](#)

3.6 дугаар зүйл. Хорооны дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах, бүртгүүлэх

[/Энэ зүйлийн нэрэнд Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2015 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хурлын 6 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/](#)

1. Хорооны дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хорооны дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг хорооны гишүүдийн хуралд биечлэн оролцож, эсхүл цахим санал хураалтаар хуралд оролцож саналаа өгсөн гишүүдийн дийлэнх олонхын саналаар батална.

[/Энэ хэсгийг Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2014 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн хурлын 85 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан, 2015 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хурлын 6 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/](#)

2. Хорооны дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт, дүрмийн шинэчилсэн найруулга нь хорооны гишүүдийн эрх ашгийг хөндсөн тохиолдолд эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй хорооны гишүүн Холбооны зөвлөлд гомдол гаргах эрхтэй.

3. Хорооны дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт, дүрмийн шинэчилсэн найруулгыг бүртгүүлэхэд Монголын Хуульчдын холбооны бүртгэлийн нэгдсэн журмын холбогдох заалтыг баримтлана.

[/Энэ хэсгийг Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2015 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хурлын 6 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/](#)

4. Хорооны дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулсан дүрэм нь Монголын Хуульчдын холбооны сайн дурын хорооны бүртгэлд бүртгэгдсэнээр хүчин төгөлдөр болно.

[/Энэ хэсэгт Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2015 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хурлын 6 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/](#)

[/Энэ зүйлийн 3 дахь хэсэг болон 5-8 дахь хэсгийг Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2015 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хурлын 6 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/](#)

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХОРООГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ

4.1 дүгээр зүйл. Хороог өөрчлөн байгуулах

1.Хороог энэ журамд заасны дагуу Хорооны гишүүдийн хурлын шийдвэрээр нийлүүлэх, нэгтгэх замаар өөрчлөн байгуулж болно.

2.Хуульд заасан тохиолдолд Холбооны зөвлөл хороог хуваах, тусгаарлах шийдвэр гаргаж болно.

3.Хороог нэгтгэхээс бусад хэлбэрээр өөрчлөн байгуулж байгаа тохиолдолд шинээр бий болж байгаа хороог Холбооны зөвлөл батламжилснаар хороог өөрчлөн байгуулагдсанд тооцно.

4.Хороог нэгтгэх хэлбэрээр өөрчлөн байгуулж байгаа тохиолдолд нэгдэж байгаа хороог бүртгэлээс хассанаар, хэрэв нэгтгэсэн хорооны дүрэмд өөрчлөлт орсон бол түүнийг бүртгэснээр тэдгээрийг өөрчлөн байгуулагдсанд тооцно.

4.2 дугаар зүйл.Хороог нийлүүлэх

1.Хоёр буюу хэд хэдэн хорооны үйл ажиллагааг зогсоож, тэдгээрийн эрх, үүргийг шинээр бий болсон хороонд шилжүүлэхийг “хороог нийлүүлэх” гэнэ.

2.Нийлж байгаа хороо тус бүрийн удирдах зөвлөл нь сайн дурын хороог нийлүүлэх замаар өөрчлөн байгуулах тухай шийдвэрийн төсөл болон шинээр бий болсон хорооны дүрэм, хороо тус бүрийн Холбооны зөвлөлд илгээсэн гишүүдээс хэнийг нь эгүүлэн татах тухай саналаа хороо тус бүрийн хорооны гишүүдийн хуралд оруулж шийдвэрлүүлнэ.

3.Хороодыг нийлүүлэх тухай шийдвэрийг хорооны гишүүдийн хуралд оролцож байгаа саналын эрхтэй гишүүдийн дийлэнх олонхын саналаар батална.

4.Хороодыг нийлүүлэх шийдвэрт шинээр үүссэн хорооны гишүүдийн хурал хуралдах хугацаа, товыг заана.

5.Хорооны гишүүдийн хурал, эсхүл цахим санал хураалтаар хорооны дүрмийг батлах, удирдах зөвлөлийн болон Холбооны зөвлөлд илгээх гишүүдийг сонгоно.

[/Энэ хэсгийг Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2014 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн хурлын 85 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан, 2015 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хурлын 6 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/](#)

4.3 дугаар зүйл.Хороог нэгтгэх

1.Хорооны үйл ажиллагааг зогсоож, түүний эрх, үүргийг өөр Хороонд шилжүүлэхийг “хороог нэгтгэх” гэнэ.

2.Нэгдэж байгаа болон нэгтгэж байгаа сайн дурын хорооны удирдах зөвлөл нь Хороог нэгтгэх тухай шийдвэрийн төслийг хороо тус бүрийн хорооны гишүүдийн хуралд оруулж шийдвэрлүүлнэ.

3.Энэ зүйлийн 2-т заасан шийдвэрийн төсөлд хороог нэгтгэх нөхцөл, журмыг тодорхойлохоос гадна нэгдэж байгаа хорооноос Холбооны зөвлөл болон бүтцийн байгууллагад илгээсэн төлөөлөгчийг эгүүлэн татах журмыг тусгасан байна.

4.Хороог нэгтгэх замаар өөрчлөн байгуулах тухай шийдвэрийг энэ зүйлийн 2-т заасан хорооны гишүүдийн хуралд оролцож байгаа гишүүдийн дийлэнх олонхын саналаар гаргана.

4.4 дүгээр зүйл.Хороог татан буулгах

1.Хороог хорооны гишүүдийн хурлын болон Холбооны зөвлөлийн шийдвэрээр Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Холбооны дүрэм, энэ журамд заасан үндэслэлээр татан буулгана.

2.Холбооны зөвлөл дор дурдсан үндэслэлээр хороог татан буулгана:

2.1.хуульд заасан Холбооны чиг үүрэг байхгүй болсон;

2.2.хорооны гишүүдийн тоо хууль, Холбооны дүрэмд заасан доод хэмжээнд хүрэхээ больсон;

2.3.хууль, Холбооны дүрэмд заасан бусад үндэслэл.

3.Хорооны гишүүдийн хурлын шийдвэрээр татан буугдаж байгаа хорооны удирдах зөвлөл нь хороог татан буулгах комисс томилох, татан буулгах хугацаа, журам, хороонд үлдэх эд хөрөнгийг Холбоонд шилжүүлэх журам зэргийг тусгасан татан буулгах төслийг хорооны гишүүдийн хуралд оруулж, хуралд оролцож байгаа саналын эрхтэй гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэнэ.

4.Татан буулгах комиссыг томилсноор тухайн Хорооны удирдлагын бүрэн эрх дуусгавар болж, татан буулгах комисст шилжих бөгөөд уг комисс нь татан буугдаж байгаа хорооны нэрийн өмнөөс Холбоотой харилцана.

5.Татан буулгах комисс үүргээ гүйцэтгэх үедээ өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас тухайн хороонд, эсхүл Холбоонд хохирол учруулсан бол уг хохирлыг хуульд заасан журмын дагуу нөхөн төлнө.

4.5 дугаар зүйл.Хороог татан буулгасан тухай мэдээлэх

1.Татан буулгах комисс нь хороог татан буулгах замаар үйл ажиллагаа дуусгавар болсон тухай Холбооны зөвлөлд мэдэгдэж, татан буулгах ажлын тайланг хүргүүлнэ.

2.Холбооны зөвлөл хороог татан буулгах шийдвэр гаргаснаар түүнийг татан буугдсанд тооцох бөгөөд энэ тухай нийтэд мэдээлнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ ХОРООНЫ САНХҮҮЖИЛТ

5.1 дүгээр зүйл.Хорооны санхүүжилт

1.Хорооны санхүүжилт нь гишүүдийн татвар, хандиваас бүрдэнэ.

2.Хороо нь Холбооны тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэхэд зориулан Холбооноос санхүүжилт, бусад этгээдээс хандив, тусламж авч болно.

3.Хорооны санхүүгийн тайлан нээлттэй байх ба санхүүгийн тайланг хагас жил тутамд Холбоонд гарган өгч, гишүүддээ тайлагнана.

4.Энэ журмын 2.1 дүгээр зүйлийн 2-т заасан хороо гишүүнчлэлийн татваргүй байх бөгөөд Холбооноос санхүүжинэ.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ ХОРООНЫ УДИРДЛАГА

6.1 дүгээр зүйл.Хорооны гишүүдийн хурал

1.Хорооны эрх барих дээд байгууллага нь Хорооны гишүүдийн хурал байна.

2.Хорооны гишүүдийн хурал ээлжит болон ээлжит бус байна.

3.Хорооны гишүүдийн ээлжит хурлыг удирдах зөвлөлийн шийдвэрээр жилд нэг удаа хуралдуулах бөгөөд хурлыг тухайн жилийн эхний улиралд багтаан зарлан хуралдуулна.

4.Энэ журмын 6.2 дугаар зүйлийн 1-д заасан эрх бүхий этгээдээс зарласан хорооны гишүүдийн хурлын бэлтгэлийг хангахад хорооны удирдлага болон эрх бүхий албан тушаалтан дэмжлэг үзүүлэх, шаардлагатай мэдээ, мэдээллээр шуурхай хангах үүрэгтэй.

5.Хорооны гишүүдийн ээлжит хурал хуралдуулахтай холбогдсон зардлыг сайн дурын хороо бүрэн хариуцна. Энэ заалт нь энэ журмын 2.1 дүгээр зүйлийн 2-т заасан хороонд хамаарахгүй.

6.Хорооны гишүүдийн хурлыг удирдах этгээдийг тухайн хурлыг зарласан этгээд хурал хуралдуулах шийдвэрт заана.

6.2 дугаар зүйл.Хорооны гишүүдийн хурал хуралдуулах тухай шийдвэр гаргах

1.Удирдах зөвлөл, эсхүл энэ журмын 6.3 дугаар зүйлийн 7-д заасан этгээд хорооны гишүүдийн хурлыг хуралдуулах тухай шийдвэрийг гаргана.

2.Хорооны гишүүдийн хурал хуралдуулах тухай шийдвэрт дараах зүйлийг заана:

2.1.хурал хуралдуулах газар, өдөр, цаг;

2.2.хурлаар хэлэлцэх асуудал;

2.3.хорооны хуралд оролцох эрхтэй гишүүдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр;

2.4.хурал хуралдуулах тухай гишүүдэд мэдэгдэх өдөр, журам;

2.5.хуралд бэлтгэх явцад хорооны гишүүдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт;

2.6.саналын хуудсаар санал авах бол саналын хуудасны агуулга;

2.7.саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдөр.

3.Хорооны гишүүдийн хурлыг энэ зүйлийн 1-д заасан шийдвэр гарснаас хойш 14-өөс доошгүй хоногийн дараа хуралдуулна.

4.Хороо энэ зүйлийн 1-д заасан шийдвэр гарснаас хойш тав хоногийн дотор хорооны гишүүдийн хурлын зарыг Холбооны вэб сайтаар болон бусад хэлбэрээр хорооны гишүүдэд хүргэх үүрэгтэй.

6.3 дугаар зүйл.Хорооны гишүүдийн ээлжит бус хурал

1.Дараах тохиолдолд удирдах зөвлөл хорооны гишүүдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулна:

1.1.удирдах зөвлөлийн нийт гишүүний 50-аас дээш хувь нь ажиллах боломжгүй буюу ажиллахгүй болсон;

1.2.хорооны нийт гишүүдийн 30 буюу түүнээс дээш хувь нь санал, шаардлага гаргасан;

1.3.удирдах зөвлөл шийдвэр гаргасан;

1.4.хорооны дүрэмд заасан бусад үндэслэл.

2.Энэ зүйлийн 1.2-т заасан этгээд хорооны гишүүдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай санал, шаардлагаа удирдах зөвлөлд гаргана.

3.Энэ зүйлийн 2-т заасан санал, шаардлагыг бичгээр гаргах бөгөөд түүнд санал, шаардлага гаргасан хорооны гишүүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, ээлжит бус хурал хуралдуулах болсон шалтгаан, хэлэлцэх асуудлыг зааж, хурлаас гаргах шийдвэрийн төслийн хамт удирдах зөвлөлд ирүүлнэ.

4.Удирдах зөвлөл нь хорооны гишүүдийн ээлжит бус хурлыг хуралдуулах тухай санал, шаардлагыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан хорооны гишүүдийн хурлыг хуралдуулах эсэх талаар шийдвэр гаргана.

5.Удирдах зөвлөл дараах тохиолдолд хорооны гишүүдийн хурал хуралдуулахаас татгалзах шийдвэр гаргах бөгөөд уг шийдвэрийн үндэслэлийн талаар энэ зүйлийн 2-т заасны дагуу санал, шаардлага гаргасан гишүүдэд нэн даруй мэдэгдэнэ:

5.1.хорооны гишүүдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай шаардлага гаргасан хорооны гишүүдийн тоо хорооны нийт гишүүдийн 30 хувьд хүрээгүй;

5.2.хорооны гишүүдийн ээлжит бус хурлаар хэлэлцэхээр санал болгож байгаа асуудал нь хорооны гишүүдийн хурлын бүрэн эрхэд хамаарахгүй.

6.Энэ зүйлийн 2-т заасны дагуу санал, шаардлага гаргасан хорооны гишүүн хорооны гишүүдийн хурлыг хуралдуулахаас татгалзсан удирдах зөвлөлийн шийдвэрийн талаар Холбооны зөвлөлд гомдол гаргаж болно.

7.Энэ зүйлийн 4-т заасан хугацаанд удирдах зөвлөл шийдвэр гаргаагүй тохиолдолд энэ зүйлийн 2-т заасны дагуу санал, шаардлага гаргасан хорооны гишүүн хорооны гишүүдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай шийдвэрийг бие даан гаргаж болно.

8.Энэ зүйлийн 7-д заасан тохиолдолд хорооны гишүүдийн хурлаас зөвшөөрвөл хурлыг зарлах, хуралдуулахтай холбогдсон зардлыг сайн дурын хороо хариуцаж болно. Энэ заалт нь энэ журмын 2.1 дүгээр зүйлийн 2-т заасан хорооны гишүүдийн ээлжит бус хуралд хамаарахгүй.

9.Удирдах зөвлөл нь энэ зүйлийн 4-т заасны дагуу хорооны гишүүдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай шийдвэр гаргасан тохиолдолд санал, шаардлага хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор тухайн хурлыг хуралдуулна.

10.Энэ зүйлийн 9-д заасан тохиолдолд хорооны гишүүдийн хурлыг хуралдуулахтай холбогдсон зардлыг сайн дурын хороо хариуцна. Энэ заалт энэ журмын 2.1 дүгээр зүйлийн 2-т заасан хорооны гишүүдийн ээлжит бус хуралд хамаарахгүй.

6.4 дүгээр зүйл.Хорооны гишүүдийн хурлын бүрэн эрх

1.Дараах асуудлыг зөвхөн хорооны гишүүдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ:

1.1.хорооны дүрэм батлах нэмэлт, өөрчлөлт оруулах;

[/Энэ заалтыг Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2014 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн хурлын 85 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/](#)

1.2.хороог өөрчлөн байгуулах;

1.3.хороог татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;

1.4.Холбооны зөвлөлд илгээх төлөөлөгчийг сонгох, эгүүлэн татах;

1.5.хорооны тэргүүн болон удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;

1.6.хорооны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;

[/Энэ хэсэг заалтыг Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2015 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хурлын 6 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/](#)

1.7.удирдах зөвлөлийн шийдвэрээр хорооны гишүүдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал;

1.8.Холбооны дүрэм, энэ журам болон хорооны дүрмээр тогтоосон бусад асуудал.

6.5 дугаар зүйл.Хорооны гишүүний саналын эрх, хорооны гишүүдийн хурлын шийдвэр хүчин төгөлдөр болох

/Энэ зүйлийн нэрийг Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2015 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хурлын 6 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/

1.Хорооны гишүүдийн хурлаар хэлэлцэж байгаа асуудлыг санал хураалтаар шийдвэрлэхэд хуралд оролцож байгаа гишүүн бүр нэг саналын эрх эдэлнэ.

2.Хуралд оролцож байгаа гишүүн нь санал хураалтаар шийдвэрлэх асуудал бүрээр санал өгөх эрхтэй.

3.Энэ журам болон хорооны дүрэмд зааснаас дээгүүр хувь тогтоогоогүй, эсхүл хуульд өөрөөр заагаагүй бол Холбооны зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг сонгохоос бусад асуудлаар гаргах шийдвэр хурал, цахим болон бусад хэлбэрээр санал хураалтад оролцсон гишүүдийн хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг сонгогдсонд тооцно.

/Энэ хэсгийг Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2014 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн хурлын 85 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан, 2016 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн хурлын 5 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/

4.Хорооны дүрэмд өөрөөр заагаагүй бол удирдах зөвлөлийн гишүүн, Холбооны зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг сонгохдоо хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг сонгоно.

5.Энэ журмын 6.4 дүгээр зүйлийн 1.1-1.4 дэх хэсэгт заасан асуудлыг хуралд оролцож байгаа гишүүдийн саналын дийлэнх олонхоор шийдвэрлэнэ.

/Энэ хэсгийг Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2016 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн хурлын 5 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

6.Хорооны гишүүдийн хурлаар хэлэлцэх асуудлын онцлогоос хамааран зарим асуудлыг хэлэлцэх журмыг хорооны дүрмээр тусгайлан тогтоож болно.

7.Хорооны гишүүдийн хурал нь хэлэлцэх асуудалд ороогүй асуудлыг хэлэлцэхгүй.

8.Шаардлагатай гэж үзвэл энэ журмын 6.8 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд хорооны гишүүдийн хурлаар хэлэлцэх асуудлыг нэмж оруулах журмыг хорооны дүрэмд зааж болно.

6.6 дугаар зүйл.Хорооны гишүүдийн хуралд оролцох эрх

1.Хорооны гишүүдийн хуралд оролцох эрхтэй гишүүдийн нэрсийн жагсаалтыг удирдах зөвлөлөөс тогтоосон бүртгэлийн өдрөөр тасалбар болгон, хуульчдын нэгдсэн бүртгэлийг хөтлөх эрх бүхий этгээд гаргаж, тухайн хурал зарласан этгээдэд хүргүүлнэ.

2.Бүртгэлийн өдрийг хорооны гишүүдийн хурал хуралдуулах тухай шийдвэр болон хорооны гишүүдийн хурлын зард заана.

3.Хорооны гишүүдийн хуралд оролцох эрхтэй хорооны гишүүдийн нэрсийн жагсаалт нь хорооны гишүүн бүрийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, ажлын газрын хаяг, эрхэлж буй ажил, албан тушаалын талаарх мэдээллийг агуулсан байна.

4.Удирдах зөвлөл хуульчдын нэгдсэн бүртгэлийг хөтлөх эрх бүхий этгээдийн бичгээр ирүүлсэн зөвшөөрлийг үндэслэн хорооны гишүүдийн хуралд оролцох эрхтэй хорооны гишүүдийн бүртгэлд өөрчлөлт оруулна.

6.7 дугаар зүйл.Хорооны гишүүдийн хурлын зарыг хүргэх

1.Хорооны гишүүдийн хурал зарласан этгээд нь тухайн хурлын зарыг хуралд оролцох эрхтэй хорооны гишүүдэд болон Холбооны Тамгын газарт мэдээлэх үүрэг хүлээнэ.

[/Энэ хэсэгт Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2015 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хурлын 6 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/](#)

2.Хорооны гишүүдийн хурлын зарыг хүргэх журам, хугацааг хорооны дүрмээр тогтооно.

3.Хорооны гишүүдийн хурлын зард хорооны оноосон нэр, хурал хийх өдөр, цаг, газар, хуралд оролцох эрхтэй хорооны гишүүдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр, хурлаар хэлэлцэх асуудал болон гаргах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам зэрэг энэ журам болон хорооны дүрмээр тогтоосон бусад мэдээллийг тусгасан байна.

4.Саналын хуудсаар санал урьдчилан авах тохиолдолд санал авах саналын хуудсыг хүлээн авах газар, сүүлчийн хугацааг тусгайлан мэдээлнэ.

5.Хорооны гишүүдийн ээлжит хурал хуралдах үед хорооны гишүүн дараах баримт бичигтэй танилцах бололцоог олгоно:

5.1.хорооны удирдах зөвлөлийн гишүүн болон Холбооны зөвлөлд илгээх нэр дэвшигчийн тухай танилцуулга;

5.2.хорооны үйл ажиллагааны тайлан;

5.3.хэлэлцэх асуудалтай холбогдсон хорооны гишүүний зайлшгүй мэдэх шаардлагатай бусад мэдээлэл.

6.Хороо нь хорооны гишүүдийн хурал хийх тухай мэдэгдэл гаргасан өдрөөс эхлэн хорооны гишүүнийг энэ зүйлийн 5-д заасан баримт бичигтэй танилцах боломжоор хангах үүрэгтэй.

6.8 дугаар зүйл.Хорооны гишүүдийн хурлын хэлэлцэх асуудалд санал оруулах

1.Хорооны нийт гишүүдийн 10 буюу түүнээс дээш хувийн гишүүний дэмжлэг авсан гишүүн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар болон удирдах зөвлөл, тооллогын комиссын гишүүн, хорооны тэргүүнд нэр дэвшүүлэх хүний талаарх саналаа хорооны гишүүдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулахаар ээлжит хурал зарлагдах сарын эхний долоо хоногийн дотор удирдах зөвлөл, эсхүл хорооны тэргүүнд гаргаж болно.

2.Хорооны тэргүүн нь энэ зүйлийн 1-д заасны дагуу ирүүлсэн саналыг удирдах зөвлөлд ажлын гурван өдөрт багтаан хүргүүлнэ.

3.Энэ зүйлийн 1-д заасан хорооны гишүүн саналаа бичгээр гаргах бөгөөд түүнд гаргаж байгаа санал, түүний үндэслэл, санал оруулж байгаа хорооны гишүүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийг тусгаж, хорооны гишүүдийн дэмжлэг авсныг нотлох баримтыг хавсаргана.

4.Энэ зүйлийн 1-д заасан хорооны гишүүн удирдах зөвлөл болон хорооны тэргүүнд нэр дэвшүүлбэл, нэр дэвшигчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, эрхэлж буй ажил, албан тушаал, нэр дэвшүүлж байгаа хорооны гишүүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийг тусгасан мэдэгдлийг бичгээр гаргах бөгөөд уг мэдэгдэлд нэр дэвшүүлж байгаа үндэслэлээ зааж болно.

5.Удирдах зөвлөл нь энэ зүйлийн 3-т заасны дагуу гаргасан саналыг дор дурьдсанаас бусад тохиолдолд хорооны гишүүдийн хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулах үүрэг хүлээнэ:

5.1.санал гаргагч нь энэ зүйлийн 1-д заасан шаардлагыг хангаагүй;

5.2.энэ зүйлийн 3, 4-т хэсэгт заасан мэдээллийг бүрэн тусгаагүй.

6.Удирдах зөвлөл нь энэ зүйлийн 3, 4-т заасны дагуу гаргасан саналыг ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулах, нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзсан бол энэ тухай үндэслэл бүхий тайлбарыг шийдвэр гаргаснаас хойш ажлын гурван өдрийн дотор санал гаргасан гишүүнд хүргүүлнэ.

7.Энэ зүйлийн 6-д заасан удирдах зөвлөлийн шийдвэрийн талаар санал гаргагч Холбооны зөвлөлд гомдол гаргаж болно.

8.Удирдах зөвлөл санал гаргагчийн зөвшөөрөлгүйгээр түүний саналыг өөрчлөх эрхгүй.

9.Хорооны гишүүдийн хурал хуралдуулах тухай шийдвэр гарснаас хойш хурлын товд өөрчлөлт оруулахыг хориглоно.

6.9 дүгээр зүйл.Хорооны гишүүдийн хурлын тооллогын комисс

1.Хорооны гишүүдийн хурлаас хурлын тооллогын комиссыг сонгоно.

2.Хорооны гишүүдийн хурлаар хэлэлцэх асуудалтай шууд холбоотой хорооны эрх бүхий албан тушаалтныг хурлын тооллогын комиссын гишүүнээр сонгохыг хориглоно.

3.Хорооны гишүүдийн хурлын тооллогын комисс дараах үүрэг хүлээнэ:

3.1.хурлын ирцийг тогтоож, хурлын даргад мэдээлэх;

3.2.тухайн хуралд оролцох эрхтэй гишүүдийн тоог, тогтоох;

3.3.хорооны гишүүдийн хуралд оролцож, санал өгөх эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан гарах асуудалд тайлбар өгөх;

3.4.санал өгөх журмыг тайлбарлах;

3.5.санал өгөх журам болон хорооны гишүүдийн санал өгөх эрхийг хангах;

3.6.санал хураалтыг саналын хуудсаар явуулж байгаа тохиолдолд уг саналын хуудсыг тоолж, хүлээн авах;

3.7.санал хураалтын дүнгийн талаар тэмдэглэл хөтлөх;

3.8.санал тоолж, санал хураалтын дүнг нэгтгэх, дүнгийн тухай шийдвэр гарган, тооллогын комиссын дарга гарын үсэг зурж, хуралд танилцуулах;

3.9.саналын хуудсыг хорооны архивт хадгалуулахаар шилжүүлэх.

4.Хорооны гишүүдийн хурлын тооллогын комиссын дарга нь тооллогын үр дүнгийн үнэн зөвийг хариуцна.

5.Удирдах зөвлөлөөс хорооны гишүүдийн хурлын тооллогын комисст хурал хуралдуулахтай холбогдсон бусад үүргийг хариуцуулж болно.

6.10 дугаар зүйл.Хорооны гишүүдийн хуралд оролцох журам

1.Хорооны гишүүн нь хорооны гишүүдийн хуралд зөвхөн өөрийн биеэр оролцоно.

2.Саналын хуудсаар саналаа ирүүлсэн хорооны гишүүнийг хорооны гишүүдийн хуралд оролцсонд тооцно.

3.Бүртгэлийн өдрөөс хойш хорооноос гарсан гишүүнийг хорооны гишүүдийн хуралд оролцуулахгүй.

6.11 дүгээр зүйл.Хорооны гишүүдийн хурлын ирц, хурал хүчин төгөлдөр болох

1.Хороонд бүртгэлтэй гишүүдийн 50-аас дээш хувь нь хорооны гишүүдийн хуралд оролцсоноор тухайн хурал хүчин төгөлдөр болно.

2.Энэ зүйлийн 1-д заасан хувьд хүрээгүй бол хорооны гишүүдийн хурлыг хүчин төгөлдөр бус гэж үзэн, тухайн хурлыг хойшлуулж, дахин хуралдах өдрийг товлох бөгөөд энэ тохиолдолд хойшлогдсон хурлаар хэлэлцэх асуудлыг өөрчлөхийг хориглоно.

3.Хорооны дүрмээр илүү өндөр хувь тогтоогоогүй бол бүртгэлтэй гишүүдийн 30 буюу түүнээс дээш хувийн хорооны гишүүд хуралд оролцсоноор энэ зүйлийн 2-т заасны дагуу хойшлогдсон хорооны гишүүдийн хурал хүчин төгөлдөр болно.

4.Хорооны дүрмээр илүү өндөр хувь тогтоогоогүй бол энэ журмын 6.4 дүгээр зүйлийн 1.1-1.6 дахь хэсэгт заасан асуудлыг хэлэлцэх хойшлогдсон хурал нь бүртгэлтэй гишүүдийн 40-өөс доошгүй хувийн гишүүд оролцсоноор хүчин төгөлдөр болно.

5.Энэ зүйлийн 2-т заасны дагуу хойшлогдсон хорооны гишүүдийн хурлыг ажлын 10 өдрийн дотор хуралдуулах бөгөөд уг хурал хуралдахаас ажлын таваас доошгүй өдрийн өмнө хорооны гишүүдийн хурал болох газар, өдөр, цагийг дахин мэдээлнэ.

6.Энэ зүйлийн 2-т заасны дагуу хойшлогдсон хорооны гишүүдийн хуралд бүртгэлийн өдрийг өөрчлөхгүй.

7 Энэ зүйлийн 2-т заасны дагуу хүчин төгөлдөр бус гэж үзсэн хорооны гишүүдийн хуралд ирүүлсэн саналыг хойшлогдсон хурлын ирц, санал хураалтын дүнд оруулан тооцно.

8.Хойшлогдсон хорооны гишүүдийн хурал нь энэ зүйлийн 5-д заасан хугацаанд хуралдаж чадаагүй бол шинээр хурал зарлах бөгөөд ирцийг энэ зүйлийн 1-д зааснаар тогтооно.

6.12 дугаар зүйл.Хорооны гишүүдийн хурал, түүний шийдвэрийн талаар гомдол гаргах

1.Хорооны гишүүдийн хурал, түүний шийдвэрийн талаар хуралд оролцоогүй, эсхүл оролцсон боловч эсрэг саналтай байсан хорооны гишүүн дараах үндэслэлээр Холбооны зөвлөлд гомдол гаргаж болно:

1.1.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, түүнд нийцүүлэн эрх бүхий байгууллагаас тогтоосон журам, хорооны дүрэмд заасны дагуу хорооны гишүүдийн хурлыг зарлаагүй;

1.2.хорооны гишүүдийн хурал хуралдах шийдвэр гарснаас хойш хуралдах өдөр, газрыг өөрчилсөн;

1.3.хурлаар хэлэлцэхээр товлоогүй асуудлыг хэлэлцсэн.

6.13 дугаар зүйл.Саналын хуудас

1.Хорооны гишүүдийн хурлаар шийдвэрлэх асуудлаар өгөх саналыг саналын хуудсаар авч болно.

2.Хорооны гишүүн энэ зүйлийн 1-д заасны дагуу өгөх саналаа саналын хуудсанд тэмдэглэн, тогтоосон журмын дагуу хорооны гишүүдийн хурлын тооллогын комисст ирүүлнэ.

3.Энэ зүйлийн 1-д заасан саналын хуудасны агуулга, загварыг хорооны гишүүдийн хурлыг зарласан этгээд батална.

4. Саналын хуудсанд дараах зүйлийг тусгана:
- 4.1. хорооны оноосон нэр;
 - 4.2. хурал хуралдах газар, өдөр, цаг;
 - 4.3. хорооны гишүүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, эрхэлж буй ажил, албан тушаал;
 - 4.4. санал хураалтаар шийдвэрлэх асуудлын томъёолол, удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;
 - 4.5. удирдах зөвлөл болон тэргүүнийг сонгоход хэрэглэх санал хураах аргын нэр.

5. Удирдах зөвлөлийн гишүүний сонгуульд ердийн журмаар саналаа өгөхөд асуудал бүрээр “зөвшөөрсөн”, “татгалзсан” аль нь болохыг тэмдэглэсэн саналын хуудсыг хэрэглэнэ.

[/Энэ хэсэгт Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2015 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хурлын 6 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/](#)

6.14 дүгээр зүйл. Саналын хуудсыг хүчинтэйд тооцох

1. Саналын хуудсаар өгсөн саналыг дараах тохиолдолд хүчинтэйд тооцно:
- 1.1. ердийн журмаар санал өгөх асуудалд санал өгөх хувилбарын зөвхөн нэгийг тэмдэглэсэн;
 - 1.2. удирдах зөвлөл болон тэргүүнийг ердийн журмаар санал хурааж сонгох тохиолдолд нэр дэвшигчийг дэмжсэн санал нь сонгогдох гишүүдийн тооноос илүүгүй байх.

6.15 дугаар зүйл. Эчнээ санал хураалтаар хорооны гишүүд шийдвэр гаргах

1. Хороо нь хорооны гишүүдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлыг хурал хуралдуулахгүйгээр хорооны гишүүдээс эчнээ санал хураалт явуулах замаар шийдвэрлэж болох бөгөөд эчнээ санал хураалтыг цахим хэлбэрээр явуулна.

[/Энэ хэсгийг Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2014 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн хурлын 85 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/](#)

[/Энэ зүйлийн 2 дахь хэсгийг Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2014 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн хурлын 85 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/](#)

2. Эчнээ санал хураалт явуулах шийдвэрийг удирдах зөвлөл гаргах бөгөөд уг шийдвэрт дараах зүйлийг тусгана:

- 2.1. эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудал;
- 2.2. саналын эрхтэй хорооны гишүүдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдөр;
- 2.3. санал хураалт явуулах цахим хаягийг гишүүдэд мэдээлэх хугацаа;

[/Энэ заалтыг Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2014 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн хурлын 85 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/](#)

- 2.4. саналын хуралт явуулах өдөр, хугацаа;
- 2.5. саналын хураалтын томъёолол болон агуулга;
- 2.6. эчнээ санал хураалт явуулахтай холбогдуулан хорооны гишүүд танилцуулах баримт бичгийн жагсаалт, тэдгээртэй танилцах газар.

3. Эчнээ санал хураалтад оролцох эрхтэй хорооны гишүүдийг энэ журмын 6.6 дугаар зүйлд заасны дагуу тодорхойлно.

4.Эчнээ санал хураалтын саналын хуудсанд энэ журмын 6.13 дугаар зүйлийн 4.1, 4.3-4.5 дахь хэсэгт заасан мэдээллийг тусгахын зэрэгцээ саналын хураалтыг явуулж эхлэх болон дуусгах хугацааг заасан байна.

[/Энэ хэсэгт Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2015 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хурлын 6 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/](#)

5.Нийт бүртгэлтэй гишүүдийн 50-аас дээш хувь нь санал хураалтад оролцсоноор эчнээ санал хураалтыг хүчинтэйд тооцох бөгөөд хурал зарласан шийдвэрт өөрөөр заагүй бол санал хураалтад **оролцсон** гишүүдийн олонхын саналаар тухайн асуудлыг шийдвэрлэнэ.

6.Эчнээ санал хураалтаар ирүүлсэн саналыг тоолох, дүнг гаргах ажлыг удирдах зөвлөлөөс томилсон комисс зохион байгуулна.

7.Хурлын тооллогын комисс нь санал хураалт явагдаж дууссанаас хойш ажлын хоёр өдрийн дотор эчнээ санал хураалтын дүнгийн тухай тайлан гаргаж, тооллогын комиссын дарга, гишүүд гарын үсэг зурж, удирдах зөвлөлд хүлээлгэн өгнө.

8.Эчнээ санал хураалтын дүнгийн тухай тайланд дараах зүйлийг тусгана:

8.1.санал хураалт явуулах мэдээллийг гишүүдэд танилцуулсан хугацаа, хэлбэр;

8.2.эчнээ санал хураалтаар шийдвэрлэсэн асуудал;

8.3.санал хураалтад оролцсон гишүүдийн нэрсийн жагсаалт;

8.4.шийдвэрлэх асуудал бүрээр гишүүдийн өгсөн саналын нийт тоо;

8.5.эчнээ санал хураалтын дүн;

8.6.эчнээ санал хураалтаар гаргасан шийдвэр.

9.Хурлын тооллогын комиссын тайланг үндэслэн удирдах зөвлөл шийдвэр гаргах бөгөөд уг шийдвэрийг тайлан хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор хорооны гишүүдэд мэдээлнэ.

6.16 дугаар зүйл.Хорооны гишүүдийн хурлын тэмдэглэл

1.Хорооны гишүүдийн хурал дууссанаас хойш ажлын 5 өдрийн дотор хурлын тэмдэглэлийг гаргаж, хурлын дарга гарын үсэг зурах бөгөөд уг тэмдэглэлийн үнэн зөвийг хурлын дарга хариуцна.

2.Хорооны гишүүдийн хурлын тэмдэглэлд дараах мэдээллийг агуулсан байна:

2.1.хурал болсон газар, он, сар, өдөр, цаг;

2.2.хурлын даргын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;

2.3.хурлаар хэлэлцсэн асуудал;

2.4.хуралд оролцох эрхтэй гишүүдийн тоо, хурлын ирц;

2.5.саналын хуудас хэрэглэсэн бол уг саналын хуудасны загвар;

2.6.хурлаар шийдвэрлэсэн асуудал тус бүрээр зөвшөөрсөн, татгалзсан саналын болон санал хураалтад оролцоогүй гишүүдийн тоо, гаргасан шийдвэрийн бүрэн томъёолол.

3.Хорооны гишүүдийн хурлын тэмдэглэлд алдаа гарсан нь уг хурлын шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болохгүй.

4.Хорооны гишүүдийн хурлын болон эчнээ санал хураалтаар гаргасан шийдвэрийг тухайн хурал дээр, эсхүл хурал дууссаны дараа санал хураалтын дүн, гаргасан хурлын шийдвэрийг хүргүүлэх замаар мэдэгдэнэ.

5.Хорооны гишүүдийн хурлын тэмдэглэлийн үнэн зөвийн баталгаа болгож, тодорхой техник хэрэгсэл ашиглан бичлэг хийж болно.

6.Энэ зүйлийн 5-д заасны дагуу бичлэг хийсэн тохиолдолд түүний хувийг хорооны архивт хадгалуулна.

6.17 дугаар зүйл.Удирдах зөвлөл

1.Хорооны гишүүдийн хурлын чөлөөт цагт хорооны эрх барих байгууллага нь удирдах зөвлөл байна.

2.Удирдах зөвлөл нь 12 хүртэл тооны гишүүнтэй байх бөгөөд хорооны нийт гишүүдийн тооноос хамаарч удирдах зөвлөлийн гишүүдийн тоог 50 хүртэл гишүүнтэй бол 5, 50-аас дээш 100 хүртэл гишүүнтэй бол 8, 100-аас дээш 200 хүртэл гишүүнтэй бол 10, 200-аас дээш гишүүнтэй бол 12 байхаар тогтоож болно.

6.18 дугаар зүйл.Удирдах зөвлөлийн бүрэн эрх

1.Удирдах зөвлөл нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Холбооны дүрэм, энэ журам болон хорооны дүрмээр хорооны гишүүдийн хурлын бүрэн эрхэд хамааруулснаас бусад дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 1.1.хорооны үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох;
- 1.2.хорооны гишүүдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;
- 1.3.хорооны гишүүдийн хурлаар хэлэлцэх асуудал, хуралд оролцох эрхтэй гишүүдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг тогтоох болон хорооны гишүүдийн хурлыг хуралдуулахтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлэх;
- 1.4.Холбооны зөвлөлийн гишүүнээс бусад бүтцийн байгууллагад хороог төлөөлөн ажиллах гишүүнд нэр дэвшүүлэх;
- 1.5.хорооны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах;
- 1.6.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Холбооны дүрэм, энэ журам болон хорооны дүрмээр тогтоосон бусад асуудал.
- 1.7.Хорооны гишүүнийг хорооноос хасах асуудлыг шийдвэрлэх;
- 1.8.Энэ журмын 6.19 дүгээр зүйлийн 3.3-т заасан үндэслэлээр Удирдах зөвлөлийн гишүүнээс хасах эсэхийг шийдвэрлэх;
- 1.9.Хорооны гишүүдийн хурлын эчнээ санал хураалтын дүнг баталгаажуулах;

[/Энэ зүйлийн 7,8,9 дэх хэсгийг Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2019 оны 6 дугаар сарын 04-ний өдрийн хурлын 10 дугаар тогтоолоор нэмсэн/](#)

6.19 дүгээр зүйл.Удирдах зөвлөлийг сонгох, бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох

1. Хорооны дүрэмд өөрөөр заагаагүй бол хорооны Удирдах зөвлөлийн гишүүний ажиллах бүрэн эрхийн хугацаа 3 жил байна.”;

2. Хорооны дүрэмд өөрөөр заагаагүй бол Удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа энэ зүйлийн 1-д заасан хугацаатай тэнцүү байх бөгөөд Удирдах зөвлөлийн гишүүнийг 2-оос дээшгүй удаа улируулан сонгож болно.;

3. Удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг дараах үндэслэлээр хугацаанаас нь өмнө дуусгавар болгож болно.

- 3.1. 6 сараас дээш хугацаагаар үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон;
 - 3.2. Удирдах зөвлөлийн гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан;
 - 3.3. Удирдах зөвлөлийн хуралд хүндэтгэн үзэх шалтгаангүй 3 ба түүнээс дээш удаа оролцоогүй бол хорооны Удирдах зөвлөлийн шийдвэрээр;
 - 3.4. Хорооны Удирдах зөвлөл, Тэргүүнээс өгсөн үүрэг даалгаврыг удаа дараа биелүүлээгүй, хорооны үйл ажиллагаанд оролцохоос шалтгаангүй татгалзсан бол;
 - 3.5. Бусад.
4. Удирдах зөвлөлийн гишүүнийг орлох этгээдийг нөхөн сонгууль явагдах хүртэл

удирдах зөвлөлөөс түр томилж болно. Нөхөн сонгогдсон гишүүний бүрэн эрхийн хугацаа өмнөх гишүүний үлдсэн бүрэн эрхийн хугацаатай тэнцүү байна.

[/Энэ зүйлийг Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2019 оны 6 дугаар сарын 04-ний өдрийн хурлын 10 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/](#)

6.20 дугаар зүйл.Удирдах зөвлөлийн дарга

1 Хорооны тэргүүн нь удирдах зөвлөлийн дарга байна.

2.Удирдах зөвлөлийн дарга нь удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, хяналт тавих үүргийг гүйцэтгэнэ.

3.Удирдах зөвлөлийн даргыг түр эзгүйд түүний үүргийг удирдах зөвлөлийн даргын, эсхүл удирдах зөвлөлөөс томилсон гишүүн гүйцэтгэнэ.

6.21 дүгээр зүйл.Удирдах зөвлөлийн хурал

1.Хорооны дүрэмд өөрөөр заагаагүй бол удирдах зөвлөлийн хурлыг сард нэг удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай гэж үзвэл нэмэлт хурал хийж болно.

2.Удирдах зөвлөлийн хурлаас тогтоол гаргах бөгөөд түүнд удирдах зөвлөлийн хурлын дарга гарын үсэг зурна.

3.Удирдах зөвлөлийн хурлыг удирдах зөвлөлийн дарга, түүний гишүүд болон хорооны дүрэмд заасан бусад этгээдийн санаачилга, шаардлагаар хуралдуулна.

4.Удирдах зөвлөл үйл ажиллагааныхаа журмыг тогтоож батлах бөгөөд удирдах зөвлөл эчнээ санал хураалтаар шийдвэр гаргаж болно.

5.Удирдах зөвлөлийн хурал гишүүдийнх нь дийлэнх олонх оролцсоноор хүчин төгөлдөр болно.

6.Хорооны дүрмээр тусгайлан өндөр хувь тогтоогоогүй бол удирдах зөвлөлийн хуралд оролцож байгаа гишүүдийн олонхын саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно.

7.Удирдах зөвлөлийн гишүүдийн тоо нь тогтоосон нийт гишүүний тооноос хоёр дахин багассан тохиолдолд хороо нь нэг сарын дотор удирдах зөвлөлийн гишүүдийг сонгохоор хорооны гишүүдийн ээлжит бус хурлыг хуралдуулна.

8.Удирдах зөвлөлийн хурлаар асуудал шийдвэрлэхэд удирдах зөвлөлийн гишүүн бүр нэг саналын эрхтэй байна.

9.Удирдах зөвлөлийн гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд даргын саналаар асуудлыг шийдвэрлэхээр хорооны дүрэм болон удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд зааж болно.

10.Удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлд дараах зүйлийг тусгана:

10.1.хурал хуралдсан газар, өдөр, цаг;

10.2.хуралд оролцсон гишүүд;

10.3.хурлаар хэлэлцсэн асуудал;

10.4.санал хураалтаар шийдвэрлэсэн асуудал болон санал хураалтын дүн;

10.5.гаргасан шийдвэр.

11.Удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлд хурал даргалагч болон хурлын нарийн бичгийн дарга гарын үсэг зурах бөгөөд тухайн тэмдэглэлийн үнэн зөвийг тухайн хурлын дарга хариуцна.

12.Удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлийг буруу хөтөлсөн нь тухайн хурлаас гаргасан шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болохгүй.

6.22 дугаар зүйл.Удирдах зөвлөлийн хурлын нарийн бичгийн дарга

1.Удирдах зөвлөлийн хурлын нарийн бичгийн даргын үүргийг Холбооны Тамгын газраас томилогдсон ажилтан гүйцэтгэнэ.

2.Удирдах зөвлөлийн хурлын нарийн бичгийн дарга дараах үүрэг хүлээнэ:

2.1.хорооны гишүүдийн хурлын болон удирдах зөвлөлийн бичиг хэргийг хариуцан хөтлөх, хорооны гишүүдэд мэдээлэл хүргэх;

2.2.хорооны гишүүдийн болон удирдах зөвлөлийн хурлын бэлтгэлийг хангах, хурлын зар, хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээлэл болон гарах шийдвэрийн төсөл, бусад баримт бичгийг зохих журмын дагуу бэлтгэх, хүргэх ажлыг зохион байгуулах;

2.3.хорооны гишүүдийн болон удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлийг хөтлөх, гарах шийдвэрийг зохих журмын дагуу баталгаажуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

2.4.хорооны гишүүдийн хурал, удирдах зөвлөл, тэргүүн болон Холбоо, Тамгын газрын хоорондын үйл ажиллагааны уялдааг хангах ажлыг зохион байгуулах;

2.5.удирдах зөвлөлийн дотоод үйл ажиллагааг хариуцан зохицуулах.

3.Холбооны Тамгын газар нь удирдах зөвлөлийн хурлын нарийн бичгийн даргын эзгүйд түүнийг орлох этгээдийг томилно.

6.23 дугаар зүйл.Хорооны тэргүүн

1.Хорооны тэргүүн нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Холбооны дүрэм, энэ журам болон хорооны дүрэмд заасан эрх хэмжээний дотор хорооны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

2.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Холбооны дүрэмд өөрөөр заагаагүй бол хорооны тэргүүн нь өөр хорооны тэргүүн байж болохгүй.

3.Тэргүүн нь Хорооны нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулах эрхтэй.

4.Хорооны Тэргүүний эрх, үүрэг

1. Тэргүүний эрх

1.1. Хороог итгэмжлэлгүйгээр төлөөлөх;

1.2. Удирдах зөвлөлийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэл хөтлүүлэх, хяналт тавих;

1.3. Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг батлах, бие даан санаачлах;

1.4. Хорооны тодорхой ажлыг хорооны гишүүн болон Удирдах зөвлөлийн гишүүнд хуваарилах;

1.5. Удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх саналыг Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэх;

1.6. Хүсэлт гаргасан хуульчийг хорооны гишүүнээр элсүүлэх хүсэлтийг бүртгэх;

1.7. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Холбооны дүрэм болон энэ журам, Холбооноос баталсан дүрэм, журамд заасан бусад эрх;

2. Тэргүүний үүрэг

2.1. Хорооны үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

2.2. Хорооны үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэх, хорооны үйл ажиллагааг идэвхжүүлэх;

2.3. Хорооны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан гаргах, холбогдох этгээдэд хүргүүлэх;

2.4. Зөвлөлд төлөөлөх гишүүний үйл ажиллагаатай хорооны үйл ажиллагааг уялдуулах;

2.5. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Холбооны дүрэм болон энэ журам, Холбооноос баталсан дүрэм, журамд захирагдах;

[/Энэ зүйлийн 4 дэх хэсгийг Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2019 оны 6 дугаар сарын 04-ний өдрийн хурлын 10 дугаар тогтоолоор нэмсэн/](#)

ДОЛДУГААР БҮЛЭГ ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН МЭДЭЭ ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦАХ, МЭДЭЭЛЭЛ АВАХ

7.1 дүгээр зүйл. Хорооны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан

1. Хороо үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангаа Холбооны Тамгын газарт болон хорооны удирдах зөвлөлд гарган өгнө.

2. Удирдах зөвлөл хорооны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, хорооны гишүүдийн хуралд оруулж хэлэлцүүлнэ.

7.2 дугаар зүйл. Хорооны баримт бичгийг хадгалах

1. Хороо нь дараах баримт бичгийг хадгалах үүрэгтэй:

1.1. Хорооны дүрэм, түүнд орсон нэмэлт, өөрчлөлт, хороог байгуулах тухай үүсгэн байгуулагчдын хурлын шийдвэр, хороог батламжилсан Холбооны зөвлөлийн тогтоол;

1.2. хорооны гишүүдийн хурал, удирдах зөвлөл, тэргүүнээс баталсан хорооны дотоод баримт бичиг;

1.3. хорооны гишүүдийн хурлын тэмдэглэл, шийдвэр;

1.4. хорооны гишүүдийн хуралд зориулан хорооны гишүүдэд тараасан баримт бичиг болон хорооны гишүүнээс хурлын хэлэлцэх асуудалд оруулахаар ирүүлсэн санал;

1.5. хорооны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан;

1.6. хорооны гишүүдийн бүртгэл, нэрсийн жагсаалт;

1.7. удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэл, шийдвэр;

1.8. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Холбооны дүрэм, энэ журам болон хорооны дүрмээр тодорхойлогдсон хорооны бусад баримт бичиг.

2. Хороо нь дараах баримт бичгийг хадгалж, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Холбооны дүрэм, энэ журам болон хорооны дүрэм, журмаар тогтоосон эрх бүхий этгээдийн шаардлагаар танилцуулах үүрэгтэй:

2.1. нягтлан бодох бүртгэлд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох баримт бичиг;

2.2. удирдах зөвлөл хурлын тэмдэглэл, шийдвэр;

2.3. хорооны тэргүүний гаргасан шийдвэр;

2.4. Холбооны эрх бүхий хяналт зохицуулалтын байгууллагад хүргүүлсэн мэдээ, тайлан.

3. Энэ зүйлийн 1-д заасан баримт бичгийг зохих журмын дагуу холбогдох этгээдээс хүлээн авч хадгалах, эрх бүхий этгээдэд танилцуулах, архивт шилжүүлэх зэрэг ажиллагааг хорооны удирдах зөвлөлийн хурлын нарийн бичгийн дарга эрхлэн гүйцэтгэнэ.

4. Хороо нь энэ зүйлийн 1-д заасан баримт бичгийг Холбооны байранд буюу хорооны гишүүдийн мэдэх, тэдний нэвтрэх боломж бүхий газар хадгална.

7.3 дугаар зүйл.Хорооны талаар мэдээлэл авах

1.Хорооны удирдах зөвлөлийн хурлын нарийн бичгийн дарга нь хорооны үйл ажиллагаанд хамаарах хууль тогтоомжоор нийтэд мэдээллэхийг хориглосноос бусад баримт бичигтэй танилцах, үнэ төлбөргүйгээр хуулбарлан авах бололцоог Холбооны Ерөнхийлөгч, Тамгын газар, хорооны гишүүний шаардсанаар олгох үүрэг хүлээнэ.

2.Холбооны зөвлөл, бусад бүтцийн байгууллага Тамгын газарт хүсэлт гаргаснаар хорооны үйл ажиллагаанд хамааралтай мэдээлэл, баримт бичгийг гаргуулан авч болно.

НАЙМДУГААР БҮЛЭГ БУСАД

8.1 дүгээр зүйл.Журам хүчин төгөлдөр болох

1.Энэ журмыг 2013 оны 11 дүгээр сарын 2-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.